
МЭДЭЭ · 2025 оны 3-р сарын 25

МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫГ ХУУЛЬ БУСААР АШИГЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХЭД АНХААРАХ АСУУДЛЫН ТАЛААР СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Нийслэлийн прокурорын газрын Хэрэг бүртгэх, Мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих II хэлтсээс Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газартай хамтран прокурор, мөрдөгч нарт мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийн онцлог, мөрдөн шалгах ажиллагааны явцад гарч буй алдаа, зөрчлийн талаарх сургалтыг зохион байгууллаа.

Тус сургалтаар мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглахтай холбоотой гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу шалган шийдвэрлэх ажиллагааг явуулахад анхаарах асуудлын талаар мэдээлэл өгч, цаашид авах арга хэмжээний талаар заавар, чиглэл өглөө.

Сургалтад нийслэлийн 9 дүүргийн прокурорын газрын 74 прокурор, нийслэлийн 9 дүүргийн Цагдаагийн газар, хэлтсийн 343 мөрдөгч болон эрх бүхий албан тушаалтнууд оролцлоо.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1111